

# DeFacto

INDEPENDENT RESEARCH INSTITUTE

**МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ**

**САНХҮҮЖҮҮЛЭХИЙН ЭСРЭГ**

**ФАТФ-ИЙН 8 ДУГААР ЗӨВЛӨМЖИЙГ  
ХЭРЭГЖИЛТИЙН АНАЛИЗ**

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Дефакто институт  
Улаанбаатар хот  
2020 он

## 1.1 УДИРТГАЛ: ФАТФ БА МОНГОЛ УЛС

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) нь 1989 онд байгуулагдсан бөгөөд мөнгө угаах, терроризмын эсрэг нэгдсэн стандартыг тогтоож, олон улсад хэрэгжүүлэх үүрэгтэй засгийн газар хоорондын байгууллага юм. Тус байгууллага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг тусгай 9, нийт 40 зөвлөмжийг авч хэрэгжүүлдэг ба гишүүн орнуудынхаа эрх зүйн зохицуулалтуудыг эдгээр стандартад нийцүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажилладаг. Улс орнууд эдгээр зөвлөмжийг өөрийн орны нөхцөлд тохируулан хууль тогтоомжууддаа тусгаж, тус байгууллагаас хэрэгжилтийг хангах зорилгоор хамтарсан үнэлгээ хийдэг. Эдүгээ ФАТФ 39 гишүүн орон, хэд хэдэн бүс нутгийн салбар байгууллагуудтай дэлхийн ихэнх улс орнуудыг үйл ажиллагаандаа багтаагаад байна. Монгол Улс тус байгууллагын Ази Номхон Далайн Бүсийн Байгууллага (APG)-д 2004 онд гишүүнээр элсэж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг тогтолцоогоо сайжруулах чиглэлд

үүрэг хүлээсэн. Улмаар 2007 онд тус байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалтуудын нийцтэй байдал болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүнд анх удаагаа үнэлгээ хийж байв. Харин ээлжит үнэлгээг 2017 онд хоёр дахь удаагаа хийж, Монгол Улсын Засгийн Газар тус үнэлгээний үр дүнд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүрэг амлалтаа өгсөн ч хангалттай ахиц дэвшил гаргаагүй гэж үзсэн. Улмаар 2019 оны 10 дугаар сараас Монгол Улс ФАТФ-ийн хяналтад буюу 'саарал жагсаалт' хэмээн нэрлэгддэг эрсдэл өндөртэй орнуудын эгнээнд ороод байгаа билээ. ФАТФ гишүүн орнуудаа энэ төрөлд хамаарах улс орнуудтай харилцахдаа үнэлгээгээр илэрсэн зөрчил дутагдалтай хэсгүүдэд анхаарч, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тодруулах болон бусад нэмэлт мэдээллийг баталгаажуулах зэргээр арга хэмжээ авахыг шаарддаг. ФАТФ-ийн 40 зөвлөмжөөс 8 дугаар зөвлөмж нь иргэний нийгэм, ашгийн бус салбарт шууд хамаарч байна.

### 8 дугаар зөвлөмж: Ашгийн бус байгууллагууд

Улс орнууд ашгийн бус байгууллагад хамаарах хууль тогтоомжууддаа онцгой анхаарал хандуулан терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглагдахгүй байх арга хэмжээ авна. Эрсдэлд суурилсан аргачлалд нийцэх тохиромжтой бөгөөд чиглэсэн арга хэмжээг эдгээр ашгийн бус байгууллагуудад авч хэрэгжүүлж, тэднийг дараах террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхэд урвуулан ашиглахаас хамгаална. Үүнд:

- (a) Хууль ёсны халхавчтай террорист байгууллагуудаас;
- (b) Хууль ёсны этгээдийг терроризмыг санхүүжүүлэх суваг болгон ашиглахаас (үүнд хөрөнгө царцаахаас зайлсхийх явдал мөн хамаарна);
- (c) Хууль ёсны дагуу зарцуулагдах хөрөнгө мөнгийг нуун далдалж, зориулалтыг нь өөрчлөх замаар террорист бүлэглэлүүдэд ашиглуулах.

### 8 дугаар зөвлөмж: Ашгийн бус байгууллагууд

ФАТФ-ийн техникийн нийцтэй байдлын үнэлгээ

**Нийцсэн (C)** – Аливаа зөрчил дутагдалгүй.

**Ихээхэн нийцсэн (LC)** – Бага зэргийн зөрчил дутагдалтай.

**Хэсэгчлэн нийцсэн (PC)** – Дунд зэргийн зөрчил дутагдалтай.

**Огт нийцээгүй (NC)** – Томоохон зөрчил дутагдалтай.

**Хэрэгжих боломжгүй (NA)** – Тухайн улсын институт, эрх зүй, бүтцийн онцлогоос шалтгаалан уг шаардлага хэрэгжих боломжгүй.

Тус зөвлөмж нь улс орнуудыг ашгийн бус салбарт хамаарах зохицуулалтаа үнэлж дүгнэн, ФАТФ-ийн стандартад нийцүүлэхийг шаарддаг. ФАТФ-ийн зүгээс уг зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ нийт салбарыг бус зөвхөн эрсдэл өндөртэй буй байгууллагуудад чиглэж ажиллахыг зөвлөдөг. Гэвч дэлхий даяар олон оронд тус зөвлөмжийг хэрэгжүүлэх явцдаа ашгийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, орон зайг хязгаарлах алхмууд түгээмэл гарсан байдаг

## 1.2 МОНГОЛ ДАХЬ АШГИЙН ТӨЛӨӨ БУС САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улс 1992 онд Үндсэн хуулиараа эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хангаж, төрийн бус байгууллагын бие даасан хуулиа 1997 онд анх баталжээ. 2017 оны хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллээр 17685 төрийн бус байгууллага албан ёсоор бүртгэлтэй байна. Үүнээс нийт бүртгэлтэй төрийн бус байгууллагуудын 48.5 хувь буюу 8578 нь үйл ажиллагаа явуулж байна. 1997 онд ТББ-ын тухай хуулийг анх баталсан цагаас хойш нийт будаагийн өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээр өөрчлөлтүүд нь бусад салбарын хуулиудын шинэчлэл, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг дагалдан оржээ (АТБХЭТ хуулийн төсөл, 2018). Улмаар Монгол Улсын Засгийн Газар хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн дагуу 2018 онд уг хуулийг шинэчлэн найруулж, Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төсөлд терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг ФАТФ-ийн зөвлөмжийг агуулсан зүйл заалтыг нэмж тусгасан<sup>1</sup>. Мөн

ТББ-уудын дийлэнх хувь нь гадны санхүүжилттэй төдийгүй энэ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд оруулж байна хэмээн хуулийн төсөл боловсруулагчдын зүгээс мэдэгдэж байв. Бодит байдал дээр ФАТФ-ийн зүгээс ийм үндэслэлээр арга хэмжээ авч ажиллахыг эрэлхийлдэггүй бөгөд салбарыг тэр чигт нь хамарсан бус зөвхөн эрсдэлтэй байгууллагуудад чиглэж ажиллахыг зөвлөдөг. Энэ нь эрсдэлд суурилсан аргачлалыг дагуу юун түрүүнд эрсдлээ тодорхойлж үнэлсний үндсэн дээр зөвхөн шаардлагатай тохилдолд нэмэлт арга хэмжээ авахыг хэлнэ (ICNL, 2020).

2017 оны 9 дүгээр сард танилцуулсан үнэлгээний тайлангаар Монгол Улс 8 дугаар зөвлөмж буюу ашгийн бус салбар дахь зөвлөмжийг хэрэгжүүлэхэд 'хэсэгчлэн нийцсэн' үнэлгээ авчээ. Тус тайланд Монгол Улс эрсдэлтэй ашгийн бус байгууллагуудыг тодорхойлоогүй төдийгүй ашгийн бус байгууллагуудад үүсч болох аюул, эрсдэлд үнэлгээ хийгээгүй хэмээн дүгнэлт гаргасан. Энэ хүрээнд дараах зөрчил, дутагдал илэрчээ. **Үүнд:**

<sup>1</sup> *Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл, 2020 он, х. 3 <https://tojha.gov.mn/wp-content/uploads/2019/10/TBB-huuliin-tusul3.pdf>*

- I) Эрсдэлтэй ашгийн бус байгууллагуудын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд хүрч ажиллаагүй,
- II) Эдгээр байгууллагуудтай хамтран терроризмыг санхүүжүүлэхэд өртөж болох эрсдлийн эсрэг сайн туршлага боловсруулаагүй,
- III) Ашгийн бус байгууллагуудыг гүйлгээ хийхдээ зохицуулалттай санхүүгийн сувгууд ашиглахыг хөхүүлэн дэмжээгүй<sup>2</sup>

Дараагаар нь монголын талаас дээрх зөрчил, дутагдлыг эсрэг арга хэмжээ авч ажиллан, үнэлгээгээ дахин шинэчлүүлэх хүсэлт гаргасан юм. ФАТФ-ын зүгээс уг хүсэлтийн дагуу 2 дахь шатны нэмэлт үнэлгээ хийсэн ч Монгол Улсыг 8 дугаар зөвлөмжөөр 'хэсэгчлэн нийцсэн' үнэлгээтэй хэвээр үлдээсэн<sup>3</sup>. Түүнчлэн Монгол Улс нэмэлт үнэлгээний үр дүнд эрсдэл өндөртэй орнуудын жагсаалтад хэвээр үлдсэн нь 8 дугаар зөвлөмж буюу ашгийн бус салбартай төдийлөн хамааралтай биш байв (ICNL, 2020).

---

2 Монгол Улс: Хамтарсан үнэлгээний тайлан, 2017, х. 111  
<http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer-fsr/Mongolia%20MER%202017%20-%20published%20version.pdf>

3 Монгол Улс: Хамтарсан үнэлгээний тайлан, 2019, х. 8  
<http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/fur/APG-Follow-Up-Report-Mongolia-2019.pdf>

## 2.1 ФАТФ-ИЙН 8 ДУГААР ЗӨВЛӨМЖ БА БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

159 орны хамтарсан үнэлгээний тайланд хийсэн шинжилгээгээр ердөө 5 орны ашгийн төлөө бус салбарт зөрчил, дутагдал илрээгүй буюу ФАТФ-ийн 8 дугаар зөвлөмжөөр 'нийцсэн' үнэлгээтэй гарчээ. Үүн дээр нэмээд 17 орон бага зэргийн зөрчил дутагдалтай буюу 'ихээхэн нийцсэн' үнэлгээтэй байна. Харин нийт орнуудын 85 хувь нь тус зөвлөмжийн хүрээнд 'хэсэгчлэн нийцсэн' эсвэл 'огт нийцээгүй' үнэлгээ авчээ. Тухайлбал 159 орноос 66 орон 8 дугаар зөвлөмжөөр 'хэсэгчлэн нийцсэн' үнэлгээ авсан бол 69 орон 'огт нийцээгүй' үнэлгээтэй байна (Transnational Institute & Statewatch 2012).

2016 онд ФАТФ-ийн 4-р шатны үнэлгээний дараах байдлаар нийт орнуудын 63 хувь нь 'хэсэгчлэн нийцсэн' болон 'огт нийцээгүй' үнэлгээтэй байсан юм<sup>4</sup>. Харин өнгөрсөн оны 12 дугаар сарын байдлаар нийт 90 оронд ээлжит үнэлгээ хийснээс одоогоор АНУ, Армен, Их Британи, Хонг Конг зэрэг 4 орон л 8 дугаар зөвлөмжөөр 'нийцсэн' үнэлгээтэй байна. Харин

60-аад орон 'хэсэгчлэн нийцсэн' болон 'огт нийцээгүй' үнэлгээтэй байна. Дийлэнх улс орнууд 8 дугаар зөвлөмжөөр нийцээгүй үнэлгээтэй гарч байгаа нь ашгийн бус салбарынхаа эрсдэлийн үнэлгээг хийгээгүйтэй шууд холбоотой юм. Түүнчлэн терроризмыг санхүүжүүлэх болон ашгийн бус байгууллагуудад үүсч болох эрсдлийн талаар төрөөс энэ төрлийн байгууллагуудтай зөвлөлдөж, мэдээллээр хангах ажлууд хийгдээгүй тохиолдолд үнэлгээ буурахад шууд нөлөөлдөг байна.

Баруун Европын зарим орнуудад ашгийн бус салбар нь салбарын тусгай хуулиуд, иргэний хууль, аж ахуй нэгж компаниудын тухай хууль зэргээр зохицуулагдаж байна. Үүнд бүртгэлийн нэгдсэн цогц системийг хөгжүүлж, хөрөнгө мөнгөний хувьд найдвартай сувгаар харилцах, гол санхүүжүүлэгчдийг ил тод байлгах зэрэг журмуудыг мөрддөг. Түүнчлэн Зүүн Ази дахь олон улсын санхүүгийн төв Хонг Конгод ТББ-уудын санхүүгийн харилцааг найдвартай сувгаар явуулах, мөнгө угаах хэрэгсэл болгож ашиглахгүй байх тал дээр хийж буй ажил нь өндрөөр үнэлэгддэг.

4 ФАТФ: 4 дүгээр шатны үнэлгээ, 2020 он <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/4th-Round-Ratings.pdf>

### 2.1.1 ИСПАНИ - 8 ДУГААР ЗӨВЛӨМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛ

Испани улсад иргэний нийгмийн байгууллагууд нь хуулийн дагуу холбоо, сан зэрэг хэлбэрээр бүртгүүлэх ба хувийн бус, нийтийн эрх ашгийн төлөө ажиллах үүрэгтэй. Эдгээр хуулийн этгээдүүд нь Холбооны эрхийн тухай, Сангийн тухай зэрэг хуулиудаар зохицуулагддаг. Жишээлбэл Сангийн тухай хуулийн дагуу аливаа сан үүсгэн байгуулахад суурь хөрөнгө 30 мянган еврогоос дээш, жилийн орлого 150 мянган еврогоос ихгүй, ажилтны тоо 5 ба түүнээс доош байх зэрэг шаардлагууд тавьдаг. Түүнчлэн эдгээр хуулиудаас гадна Иргэний хуульд бусад чиглэл, үйл ажиллагааг хамарсан зохицуулалтууд үйлчилдэг.

Испани Улс нь 2014 болон 2019 оны хамтарсан үнэлгээний тайлангаар 8 дугаар зөвлөмжид 'ихээхэн нийцсэн' үнэлгээ авчээ. Энэ хүрээнд ашгийн бус байгууллагуудын хяналтын тогтолцоог өргөжүүлж, 100 еврогоос дээш хандив өгсөн болон хүлээн авсан

этгээд бүрийг тодруулах шаардлага тавьсан зэргийг харгалзан дүгнэжээ (Bartolozzi et.al, 2019). Испанийн бүрэн эрхт 17 муж нь өөрийн нутаг дэвсгэр дээр ашгийн бус байгууллагуудыг хянах тусгай хууль хэрэгжүүлэх эрхтэй хэдий ч санхүү, татварын хувьд холбооны засгийн газарт захирагддаг. Энэхүү бүрэн эрхт мужуудаас бүрдэх холбооны систем нь Испанид ашгийн бус байгууллагуудын мэдээллийг хадгалах үндэсний 8, орон нутгийн 78 агентлагийг бий болгожээ. ФАТФ тус бүтцийг хэт нүсэр гэж дүгнэн, тус салбараар дамжуулж терроризмийг санхүүжүүлэхээс сэргийлэхэд удаашрал үүсгэж, хяналтыг сулруулахад нөлөөлж байна гэжээ. Гэхдээ Испани улсын олон нийтийн төлөө холбоод, сангууд болон шашны байгууллагуудыг хянах тогтолцоо нь 8 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ихээхэн нийцтэй байна.

## 2.1.2 ИХ БРИТАНИ - 8 ДУГААР ЗӨВЛӨМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛ

Их Британи Улс 2018 оны 12 дугаар сарын хамтарсан үнэлгээний тайланд 8 дугаар зөвлөмжид 'нийцсэн' үнэлгээ авсан бөгөөд тус улс ашгийн бус байгууллагууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдах эрсдэл өндөр буйг хүлээн зөвшөөрч, бодит алхмуудыг шат дараатайгаар, тууштай авч хэрэгжүүлснийг тэмдэглэжээ. Их Британи өмнөх буюу 3 дахь удаагийн үнэлгээнд тус зөвлөмжөөр 'ихээхэн нийцсэн' үнэлгээ авсан байв. Улмаар ФАТФ тус улсын засгийн газар терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд ихээхэн хичээл зүтгэл гаргаж, ашгийн бус салбартаа анхаарч ажилласныг харгалзан үзэж 2018 оны тайланд үнэлгээгээ шинэчилсэн юм.

Их Британид 900 мянга гаруй ашгийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна (FATF, 2018). Энэхүү томоохон салбарыг бүртгэж, зохицуулдаг 3 байгууллага нь Англи, Уэльсийн Буяны Комисс (CSEW), Шотландын Буяны Зохицуулах Алба (OSCR) болон Умард Ирландын Буяны Комисс (CCNI) юм. Эдгээр байгууллагууд нь өмнө дурдсан Испани Улс дахь ашгийн бус салбарыг зохицуулах нүсэр тогтолцоотой харьцуулахад илүү үр дүнтэй харагдаж байна. ФАТФ-ын зүгээс салбарын эрсдлийн үнэлгээгээ хэд хэдэн удаа хийж, хууль тогтоомжуудаа сайжруулах замаар хяналтын байгууллагуудын

эрх мэдлийг нэмэгдүүлж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд холбогдсон гэмт хэргүүдийг далайцтайгаар шийдсэн зэргийг дурджээ. Улмаар тус улсын засгийн газар үүсээд буй аюул эрсдлээ тодорхойлж, түүнд тохирсон бодитой хариу арга хэмжээнүүдийг авсан гэж дүгнэсэн байна. Тухайлбал Үндэсний эрсдлийн үнэлгээг 2015, 2017 онуудад тус тус хийж гүйцэтгэжээ. Мөн 2016, 2017 онд Ашгийн бус салбарын менежмент, Дотоодын ашгийн бус салбарын тойм зэргийг хийснийг онцолсон байна. ФАТФ-ын зүгээс эдгээр үнэлгээ нь чанарын шаардлага хангасан төдийгүй тус улсын ашгийн бус салбар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөх боломжтойг таньж, ач холбогдол өгч ажилласан гэж үзэх гол үндэслэл болжээ.

2016 онд Charities Act батлагдаж, 2017 оноос үйлчилж эхэлснээр ТББ, сангуудын санхүүгийн тайланг нарийвчлах эрх зүйн орчин бүрдсэн юм. Улмаар дээр дурдсан хяналт, зохицуулалтын гурван байгууллага ТББ, сангуудад цогц хяналт тавих, шаардлага тохиолдолд татан буулгах хүртэл арга хэмжээ авах эрх мэдэл нэмж олгожээ. Санхүүгийн шилжүүлгүүдийг хянах, мөнгөн хөрөнгийг хураах авах зэрэг үйл ажиллагаанууд нь өргөн хүрээнд, үр дүнтэй төдийгүй хууль ёсны байгааг тус улсад тулгараад



буй терроризмын аюулын эсрэг зүй зохистой арга хэмжээ хэмээн сайшаасан байна. Дээр дурдсан гурван байгууллага нь ашгийн бус салбартайгаа нягт хамтран ажилладаг ба мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан сургалт тогтмол хийдэг. Эдгээр байгууллагуудаас хамтран гаргасан гарын авлага нь албан

ёсны зохицуулалттай санхүүгийн сувгийг ашиглан мөнгөний урсгалаа явуулахыг ТББ-уудаас шаарддаг. Их Британид үйл ажиллагаа явуулж буй буяны байгууллагууд зорилгодоо нийцээгүй үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд зөрчлөөс нь хамаарч хориг арга хэмжээ авдаг. Тухайлбал данс царцаах, бүртгэлээс хасах, торгууль ногдуулах гэх мэт.

### 2.1.3 ХОНГ КОНГ - 8 ДУГААР ЗӨВЛӨМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛ

БНХАУ-ын тусгай захиргааны бүс болох Хонг Конг нь 2019 оны 9 сарын байдлаар Их Британийн адил 8 дугаар зөвлөмжөөр нийцсэн үнэлгээ авсан нь ФАТФ-аас хийсэн өмнөх 2012 оны үнэлгээнээс нэг шат ахисан үзүүлэлт юм. Юуны өмнө Хонг Конг нь олон улсын санхүүгийн төвийн хувьд тус улсын газар нутаг, санхүүгийн сувгаар дамжин хилийн чанадад болон эх газрын БНХАУ-д терроризмыг санхүүжүүлэх эрсдэл байгааг хүлээн зөвшөөрсөн байдаг. Тус улс доотодын ашгийн бус байгууллагуудаа эрсдлийн хувьд доогуур хэмээн үнэлж, ашгийн бус олон улсын байгууллагуудын эрсдэлд илүүтэй анхаарал хандуулжээ. ФАТФ-аас тус улсын Засгийн газрын тооцоолсон хяналтын түвшин, энэ чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг тохиромжтой хэмээн дүгнэсэн байдаг. Түүнчлэн терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах гэмт хэргийг шийтгэх, хөрөнгө

битүүмжлэх, хураан авах зэрэг механизмууд нь ФАТФ-ын стандартууд болон 8 дугаар зөвлөмжид нийцсэн байна. 2018 онд салбарын эрсдлийн үнэлгээгээ шинэчилж, бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ, буяны сангуудаас хичнээн нь ФАТФ-ын шалгуураар ашгийн бус байгууллагын ангилалд багтаж байгааг тодруулах, аль нь эрсдэл илүү өндөр буйг тогтоох, тэрхүү эрсдэл бүхий бүлэгт санхүүгийн хяналт тавих зэрэг ажлуудыг тус тус зохион байгуулжээ. Тухайлбал хоршоо, компани эсвэл итгэлцэл хэлбэрээр байгуулагдсан ашгийн бус байгууллагууд орлогын эх үүсвэр, зарлагаа тайлагнах үүрэгтэй бөгөөд хуулийг дагаж мөрдөөгүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

Түүнчлэн Татварын албанд татвараас чөлөөлөгдсөн ашгийн бус байгууллагуудыг хянах, эрхийг нь түдгэлзүүлэх зэрэг чиг үүргийг

нэмж олгосон бөгөөд татвараас зайлсхийх зорилгоор санхүүгээ худал тайлагнасан тохиолдолд хувь хүн болон хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. Нийгмийн хамгааллын хэлтэс нь нийтэд тустай үйл ажиллагаанд зориулсан санхүүжилтийг хүлээн авагч ТББ, сангуудыг хянах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус хэлтсээс ашгийн бус байгууллагуудад зориулсан

Сайн туршлагын гарын авлага боловсруулж, санхүүжилт хүлээн авсан байгууллагуудаас хичнээн байгууллага нь уг заавар, зөвлөмжийг хэрэгжүүлж буйг статистикаар тайлагнасан байдаг. Энэ нь тус бүс нутгийн засаг захиргаа иргэний нийгэм, ашгийн бус байгууллагуудыг хуулийн хүрээнд зохицуулж, тэдгээр байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладгийг харуулж байгаа юм.

### 3 ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол улсад иргэний нийгмийн эрх чөлөөг хязгаарлалгүйгээр ТББ-уудыг хянаж, зохицуулах, санхүүгийн шилэн байдлыг хангахад Их Британийн үлгэр жишээгээр цөөн боловч үр өгөөжтэй ажилладаг, хараат бус байгууллага хэрэгтэй байна. Тэдгээр нь эрсдэлийн үнэлгээг чанарын өндөр төвшинд хийж, тэрхүү үнэлгээтэй уялдуулж бодит арга хэмжээг авч чадвал 8 дугаар зөвлөмжид хэсэгчлэн нийцсэнээ (РС) ахиулж болно. Мөн Их Британид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон ашгийн бус байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас гажсан хувь

хүмүүс, хуулийн этгээдүүдийг бүгдийг шийтгэсэн жишгээр Монгол улс ч бас тухайн зөрчлүүдийг бодитоор шийтгэх хэрэгтэй байна. Сангуудын хөрөнгийн тухай, ашгийн бус сангуудыг зохицуулсан Испани улсын туршлагыг судлан, Монголын хөрсөнд буусан хөрөнгийн хязгаарлалт, доод хэмжээ зэргийг тогтоох боломжтой. БНХАУ-ын тусгай захиргааны бүс Хонг Конгийг үлгэрлэн Монголын төрийн зохих алба нь ард иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад сайтар мэдээлэл түгээх, тэдэнтэй ойр хамран ажиллах, тус салбарын эрсдэлийг тооцоолж, таниулах хэрэгтэй байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ♦ FATF (2019). 2nd Follow-up Report, Mutual Evaluation of Mongolia. Sydney South, Australia: APG
- ♦ Retrieved from: <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/fur/APG-Follow-Up-wReport-Mongolia-2019.pdf>
- ♦ FATF (2017). Anti-money laundering and counter-terrorist financing measures, Mongolia – Mutual Evaluation Report. Sydney South, Australia: APG
- ♦ Retrieved from: <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer-fsrb/Mongolia%20MER%202017%20-%20published%20version.pdf>
- ♦ FATF (2018). Anti-money laundering and counter-terrorist financing measures - Spain,
- ♦ 5th Year Follow-Up Assessment Report of Spain. Paris, France: FATF
- ♦ Retrieved from: <http://www.fatf-gafi.org/publications/mutualevaluations/documents/fuar-spain-2019.html>
- ♦ FATF (2018). Anti-money laundering and counter-terrorist financing measures – United Kingdom, Fourth Round Mutual Evaluation Report. Paris, France: FATF
- ♦ Retrieved from: <http://www.fatf-gafi.org/publications/mutualevaluations/documents/mer-united-kingdom-2018.html>
- ♦ FATF (2019), Anti-money laundering and counter-terrorist financing measures – Hong Kong, China, Fourth Round Mutual Evaluation Report. Paris, France: FATF
- ♦ Retrieved from: <http://www.fatf-gafi.org/publications/mutualevaluations/documents/mer-hong-kong-china-2019.html>
- ♦ Chris Galloway (2015). Banking Non-Profit Organizations – How Financial Institutions Can Avoid Wholesale De-Risking NPOs by Mitigating Money Laundering and Terrorist Financing Risks Posed by the Sector. ACAMS
- ♦ Retrieved from: <http://www.acams.org/wp-content/uploads/2015/08/Bank->

*ing-Non-Profit-Organizations-NPOs-C-Galloway.pdf*

- ♦ FATF (2015). Best Practices: Combating the Abuse of Non-Profit Organisations (Recommendation 8). Paris, France: FATF
- ♦ Retrieved from: <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/BPP-combating-abuse-non-profit-organisations.pdf>
- ♦ Ben Hayes (2012). Counter-Terrorism, Policy Laundering and the FATF: Legalising Surveillance, Regulating Civil Society. Amsterdam, Netherlands: Transnational Institute and Statewatch
- ♦ Retrieved from: <https://www.tni.org/en/publication/counter-terrorism-policy-laundering-and-the-fatf>
- ♦ European policy on high-risk third countries. (2020). Retrieved May 22, 2020, from [https://ec.europa.eu/info/business-economy-euro/banking-and-finance/financial-supervision-and-risk-management/anti-money-laundering-and-counter-terrorist-financing/eu-policy-high-risk-third-countries\\_en](https://ec.europa.eu/info/business-economy-euro/banking-and-finance/financial-supervision-and-risk-management/anti-money-laundering-and-counter-terrorist-financing/eu-policy-high-risk-third-countries_en)
- ♦ FATF (2019). FATF 4thRound Ratings. (updated April 2020.). Paris, France: FATF
- ♦ Retrieved from: <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/4th-Round-Ratings.pdf>
- ♦ ECNL, EFC, HSC (2015). Good Practices in applying FATF standards. Hague, Netherlands: Open Society Foundations
- ♦ Retrieved from: <http://fatfplatform.org/governments-good-practice-recommendations/>
- ♦ ECNL, HSC (2017). How Can Civil Society Effectively Engage in Counter-Terrorism Processes?. Hague, Netherlands: Open Society Foundations
- ♦ Retrieved from: <http://fatfplatform.org/governments-good-practice-recommendations/>
- ♦ ECNL, EFC, HSC (2015). Illustrative List of Overregulation of Non-Profit Organizations. Hague, Netherlands: Open Society Foundations

- ♦ Retrieved from: [http://fatfplatform.org/wp-content/uploads/2015/10/Catas-logue-of-government-overregulation-July-2015\\_final-.pdf](http://fatfplatform.org/wp-content/uploads/2015/10/Catas-logue-of-government-overregulation-July-2015_final-.pdf)
- ♦ FATF (2012-2019). International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation. Paris, France: FATF.
- ♦ Retrieved from: <https://www.fatf-gafi.org/recommendations.html>
- ♦ OECD/FATF (2012). Interpretive Note to Recommendation 8. Seoul, South Korea: FATF
- ♦ Retrieved from: <http://fatfplatform.org/wp-content/uploads/2015/02/Interpretive-Note-to-Recommendation-8.pdf>
- ♦ FATF (2013-2019). Methodology for Assessing Compliance with the FATF Recommendations and the Effectiveness of AML/CFT Systems. (updated October 2019.). Paris, France: FATF Retrieved from: <http://www.fatf-gafi.org/publications/mutualevaluations/documents/fatf-methodology.html>
- ♦ Omar, N., Johari, Z., Arshad, R. (2014). Money laundering - FATF special recommendation VIII: a review of evaluation reports. Selangor, Malaysia: Procedia
- ♦ Retrieved from <https://www.sciencedirect.com/science/article/pii/S1877042814038877>
- ♦ Revision of the NGO law in Mongolia. (2018). Retrieved May 22, 2020, from <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2018/10/TBB-huuliin-uzel-barimtlal.pdf>
- ♦ FATF (2019). 2nd Follow-up Report, Mutual Evaluation of Mongolia. Sydney South, Australia: APG
- ♦ Retrieved from: <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/fur/APG-Follow-Up-Report-Mongolia-2019.pdf>